



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/142

Улаан-Уул

Сумын төвийн өвөлжилтийн бэлтгэл
хангах ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, сумын Онцгой комиссийн 10 дугаар хуралдааны хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Сумын төвийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, инженерийн шугам сүлжээний доголдол, хэрэглэгчдийн гомдол саналыг барагдуулах, шугам сүлжээний тохиргоо хийх асуудлаар “Иргэдийн оролцоотой-Сумын төвийн шинэчлэл” төслийн гүйцэтгэгч “Бурхант хясаа” ХХК-ийн төлөөлөл, сумын дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг гүйцэтгэх “Скэй” ХХК-ийн төлөөлөлтэй хамтран ажилласан дүнгийн тухай сумын Онцгой комиссын хурлаас гарсан дараах шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, дулаан хэрэглэгч айл өрхүүдэд үүрэг болгосугай.

1.1.Дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг доголдолгүй явуулж, дулаан хэрэглэгч байгууллага, айл өрхийн шугам дахь усны крантыг салган авч, зөвхөн зориулалтын хий авагчтай болгох, шугам сүлжээний тохируулга хийх, худгуудыг цоожтой болгох, соёлтой хэрэглээг хэвшүүлэх ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор хийж дуусган, тайлан мэдээ ирүүлэхийг дулаан үйлдвэрлэгч “Скейл” ХХК-ны захирал Б.Мөнгөнтуулд.

1.2.Дулаан алдагдлыг илрүүлэх, бууруулах чиглэлээр шуурхай арга хэмжээ авч, хэрэгжүүлэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор танилцуулахыг байгууллагын дарга, захирал, дулаан хэрэглэгч айл өрхүүдэд.

1.3.Байгууллагын дотоод шугам сүлжээний бүрэн бүтэн байдал, бохирдлыг жил тутам мэргэжлийн байгууллагын оролцоотой шалгаж, цэвэрлэж хэвших, холбогдон гарах зардлыг төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг байгууллагын дарга, нягтлан бодогч, нярав нарт.

642201298

2.“Иргэдийн оролцоотой-Сумын төвийн шинэчлэл” төслийн инженерийн бүхий байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах, алдаа доголдлыг шуурхай илрүүлэх, хариу арга хэмжээ авах, байгууллагын дотоод шугам сүлжээний ашиглалтыг сайжруулах зэрэгт анхааран байгууллага бүр мэргэжлийн ажилтантай болох, зарим ажилтаны ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулж мэргэшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт даалгасугай.

3.Дулаан хэрэглэгч байгууллага, айл өрхийн шугам дахь усны крантыг салгах, зөвхөн зориулалтын хий авагчтай болгох, шугам сүлжээний тохируулга хийх, худгуудыг цоожтой болгох, соёлтой хэрэглээг хэвшүүлэх нөлөөллийн ажил үүргийг гүйцэтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:Г.Баттогтох (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Д.Нарантуяа (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга) (өөртэй нь зөвшилцснөөр)
Г.Нямдаваа (6 дугаар багийн Засаг дарга)
Г.Төрболд (“Скэй” ХХК-ийн төлөөлөл)
С.Анхбаяр (“Скэй” ХХК-ийн сантехникч)

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын хэсгийн тайланг илтгэх хуудсаар танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ